

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхэд ямар хугацаа үйлчлэх вэ?

Хэрэг үүсгэх

5 хоног

/ИХШШТХ-ийн § 75.3.1/

Нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх

Нэг удаа хэрэг үүсгэснээс хойш
5 хоногийн дотор

/ИХШШТХ-ийн § 75.5.5/

Нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх

Нэхэмжлэлийг гардан авснаас хойш
5 хүртэл хоногийн дотор

/ИХШШТХ-ийн § 75.5.4/

Сөрөг нэхэмжлэл гаргах

Нэхэмжлэлийг гардаж авснаас хойш
7 хоногийн дотор

/ИХШШТХ-ийн § 75.5.2/

Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

45 хоног

/ИХШШТХ-ийн § 75.2.3/

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгах

Нэг удаа
14 хүртэл хоног

/ИХШШТХ-ийн § 75.2.4/

Давж заалдах журмаар гомдол гаргах хугацаа

7 хоног

/ИХШШТХ-ийн § 75.11.1/

Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа /дахин хэлэлцүүлэхээр буцаасан/

14 хоног

/ИХШШТХ-ийн § 75.2.3/

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх зарчим, онцлог



ШҮҮГЧ ДАНГААР,
НЭГ ШҮҮХ ХУРАЛДААНААР ШИЙДВЭРЛЭНЭ.



Бичмэл баримт



Цахим баримт

1. Шүүхийн мэдээллийн системд өөрийн эрхээр нэвтрэн байршуулах

2. Шүүхтэй харилцааар сонгосон цахим шудангийн хаягаар илгээх



Зохигч шүүх хуралдаанаас өмнө шаардлага, татгалзлаа нотлох баримт гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцохгүй бол хэрэгт байгаа баримтын хүрээнд шийдвэр гаргана. Энэ шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулахгүй.



Хангалттай гэж үзвэл шүүхээс нотлох баримтаар үнэлж болно.



Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтайгаар гэрч, шүүгч, зохигч нэгэн зэрэг холбогдон авсан гэрчийн мэдүүлэг

Хуульд заасан эрх, үүргээ ойлгож, үнэн зөв мэдүүлснээ илэрхийлэн нотариатаар гэрчлүүлсэн гэрчийн мэдүүлэг

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах ажиллагаа хийгдэхгүй.




▶ Нэгтгэх, тусгаарлах



- ▶ Хамтран нэхэмжлэгч татах
- ▶ Хамтран хариуцагч татах
- ▶ Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд татах

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд тэдгээр нь бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр оролцож болно.

Нэхэмжлэл гардуулах



Иргэн бол түүнтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар мэдэгдэх илгээнэ.

Хуулийн этгээд бол түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар илгээнэ.


Өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээх

Эрх, үүргийн тайлбар



Мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр нэхэмжлэлийг гардаж авсан гэж үзнэ. /ИХШХШТХ-ийн 75.2/

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх



1. Хугацаа үргэлжилж тоологдоно.
2. Тогтоосон тов хэвээр байна.

- ▶ Тусгайлсан журмаар шийдвэрлэхгүй нэхэмжлэл хүлээн авсан, иргэний хэрэг үүсгэсэн.
- ▶ Тухайн хэрэг эрх зүйн шинэ ойлголт, хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзсэн.

Шүүхийн шийдвэр

1. ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭНЭ.



2. ШҮҮХ ХУРАЛДААНААС ШИЙДВЭР



Танилцуулага Тайлбар, Маягт Нэхэмжлэл Гарын авлага

ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Иргэний зарим төрлийн хэрэг, маргааныг ердийн бусад хэргээс богино хугацаанд хялбар, зардал багатайгаар явуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг **Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа** гэнэ.

Ямар төрлийн маргааныг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх вэ?

Бүх төрлийн гэрээ хэлцлээс үүссэн нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй **МӨНГӨН ХӨРӨНГӨ** нэхэмжлэл буюу 2024 оны байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хөдөлмөрийн хөлсний доод 660,000 төгрөгийг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ **13,200,000** төгрөгөөс доош үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэл хамаарна. /ИХШХШТХ-ийн § 75.1.1 /

- Бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах
- Дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах
- Хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах
- Бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрх битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол

Гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах

Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны олговор гаргуулах дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах

Нэхэмжлэлийн үнийн дүнгээс үл хамаарч тусгайлсан журмаар шийдвэрлэнэ. /ИХШХШТХ-ийн § 75.1.2 /